

Говь-Алтай аймгийн Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл,
гомдлын шийдвэрлэлтийн байдал
/2022 оны 3-р улирлын байдлаар, өссөн дүнгээр/

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувиар
			Нийт шийдвэрлэж хариу өгсөн	Үүнээс			
				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвд ирсэн	36	30	19	0	6	83.3%
2	Хүний эрхийн үндэсний комисс, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хүний эрхийн үндэсний комиссоос шилжин ирсэн	3	3	3	0	0	100.0%
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	251	222	85	3	29	88.4%
2	Сумдын Засаг даргын Тамгын газар	1345	1218	6	0	127	90.6%
3	Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг	895	849	15	1	49	94.9%
Дүн		2530	2322	128	4	208	91.8%

Говь-Алтай аймгийн Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл,
гомдлыг хүлээн авсан байдал
/2022 оны 3-р улирлын байдлаар, өссөн дүнгээр/

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн хандсан	Бусад
1	Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвд ирсэн	36	0	1	35	0	0
2	Хүний эрхийн үндэсний комисс, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хүний эрхийн үндэсний комиссоос шилжин ирсэн	3	2	1	0	0	0
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	251	72	0	179	0	0
4	Сумдын Засаг даргын Тамгын газар	1345	1131	150	40	24	0
5	Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг	895	792	13	13	4	0
Дүн		2530	1997	238	267	28	0

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2022 ОНЫ 3-Р УЛИРЛЫНТАЙЛАН

2022.10.03

Алтай хот

“Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, 18 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 23 агентлагт 2022 оны 3-р улирлын байдлаар иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ, тайланг нэгтгэн гаргалаа.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хуралдаан, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд аймаг нийслэлийн Засаг дарга нарт өгсөн үүрэг, даалгаврын дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг бодитой шийдвэрлэх, шат дамжлагыг багасгах, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангаж, хүндрэлтэй асуудлыг шуурхай шийдвэрлэх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж, тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэх, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 187 дугаар тогтоолын дагуу Иргэд, олон нийттэй харилцах 1111 төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 1111 төв”-өөс тус аймагтай холбоотой 7 хүсэлт, 26 гомдол, 3 санал, нийт 36 өргөдөл, гомдол шилжин ирж, эрх бүхий албан тушаалтан, байгууллагад хүргүүлэн, 30 өргөдлийг шийдвэрлэж, шийдвэрлэлт 83,3 хувьтай байна. Агуулгаар нь авч үзвэл төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой 9, төрийн албан хаагчийн ёс зүй, ур чадвартай холбоотой 7, эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой 9, төсөл хөтөлбөрт хамрагдахыг хүссэн 3, газрын маргаантай асуудлаар 2, бусад асуудлаар 5 өргөдөл, гомдол байна. Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дийлэнх хувийг эзэлж байгаа эмнэлгийн байгууллагын үйлчилгээ, чанар, хүртээмж, эмч эмнэлгийн ажиллагсдын ёс зүй, ур чадвартай холбоотой өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийн, ажил сайжруулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, өргөдөл, гомдлыг бууруулах, ажлын сахилга хариуцлагыг сайжруулах тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг даалгавар өгч ажиллалаа. Нэгдсэн эмнэлгийн Эрт илрүүлгийн шинжилгээ хариуцсан Ш.Сэлэнгэ эмчтэй холбогдож холбогдох тайлбарыг авсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дурангийн шинжилгээний нэг эмч байдаг бөгөөд, Улаанбаатар хотод сургалтад сурч, шалгалт өгөх зайлшгүй шаардлага гарсан тул одоогоор дурангийн шинжилгээ хийгдэхгүй хүлээлттэй байна. Дурангийн шинжилгээнд өдөрт 40-50 хүнд үйлчилдэг асар их ачаалал ихтэй байдаг. Эрт илрүүлгийн шинжилгээнд 1 шинжилгээ нь хийгдээгүй тохиолдолд санхүүжилт орж ирдэггүй. Мөн эрт илрүүлгийн шинжилгээнд ашиглаж байгаа программ нь бүрэн ашиглагдаагүй, 06 дугаар сарын 15-ны өдрөөс ашиглаж эхэлсэн тул механик ажиллагаа маш их байдаг байна.

Бигэр шимт элс сувиллыг хариуцсан албан хаагчтай холбогдож иргэний гомдлыг хүргэсэн. Иргэдэд амрах болон илгээх бичиг аван сувиллаар үйлчлүүлэх тухай мэдээллийн хэрэгслээр, албан ёсны фэйсбүүк хуудсаар байнга мэдээллэж байгаа боловч илгээх бичиг авахгүй ирснээс үүдэн ачаалал үүсч байна. Үйлчлүүлэгчдийг аль болох богино хугацаанд байраар хангахад анхаарч ажиллаж байна. Тухайн үед үйлчлүүлэгчтэй буруу ойлголцож харилцааны зөрчил үүсгэсэн тул ахин ийм зөрчил гаргахгүй байх талаар санууллаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн албан тушаалд эргүүлэн тавих болон, ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн авах тухай иргэний гомдлыг судлан, захиргааны хэргийг давж заалдах шатны шүүхийн магадлалаар анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан байх тул шүүхийн шийдвэр гарсны дараа тухайн гомдлыг эргэн тайлагнах тухай аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн албан тоотой хариуг хүргүүлээ.

Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй холбоотой гомдлыг судлан, холбогдох тайлбар мэдээллийг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 1/5989 тоот албан бичгээр хүргүүлээ. Аймгийн албан ёсны цахим хуудсаар 1 өргөдөл хүлээн авч Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэн шийдвэрлэлээ. Үйлчилгээний нэгдсэн төвд байх саналын хүсэлтийн хайрцагт санал, хүсэлт ирээгүй.

Тайлан мэдээнд тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас байгууллагын удирдлагад гаргасан ээлжийн амралт, захиргааны чөлөө, цалингийн нэмэгдэл, шилжин ажиллах гэх мэт хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдөл, тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой үйлчилгээний хүсэлтийг тайлан мэдээнд тусгахгүй байх талаар Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл өгсний дагуу аймгийн хэмжээнд Хөдөлмөр халамжийн 2094, Нийгмийн даатгалын 1149, Улсын бүртгэлийн 1371, Газрын харилцааны 1106, Татварын 168 үйлчилгээ авах хүсэлт, Хөдөлмөрийн харилцаатай холбоотой 619, нийт 6507 өргөдлийг тайлан мэдээнээс хасаж, 2530 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг тайлагналаа.

Аймгийн хэмжээгээр нийт өргөдлийн шийдвэрлэлт 91,8% байна.

Нийт өргөдөл гомдлын 21,4% буюу 540 нь ажилд орохыг хүссэн өргөдөл эзэлж байна. Эдгээрээс 323 хүнийг байнгын болон түр ажлын байраар хангаж, ажлын байрны тусгай шаардлагыг хангах, идэвхитэй ажил хайгчаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлэх талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймаг орон нутгийн зүгээс ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, иргэдийн амьжиргааг дэмжих, боловсролын чанарыг сайжруулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгооны хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан оношилгоо, эмчилгээний нэгжүүдийг өргөтгөн байгуулж, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр анхааран ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт батлагдсан гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгож, залуучуудын бизнес санааг хөгжүүлэх, залуучуудаар удирдуулсан бизнесийг шинээр бий болгох START UP арга хэмжээг хэрэгжүүлж, 200-аас

доошгүй ажлын байр шинээр бий болгох болон Сум бүрт Алтайн брэндийг хөгжүүлж, орон нутгийн баялаг бүтээгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалт, маркетингийг дэмжсэн борлуулалтын төв, интернэт худалдааны сүлжээг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран бий болгох зэрэг хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд залуусаа мэдлэг ур чадвартай өөрийн гэсэн ажлын байр орон нутгаа хөгжүүлэх, ажлын байр, хүний нөөц бололцоог бүрдүүлэн нэмэгдүүлэх, хүн амыг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ханган, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгохоос гадна орон нутгаа сурталчилах, орчин үеийн техник технологитой хөл нийлүүлэн алхах, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогыг бодитойгоор дэмжих нөхцөл бүрдэх юм.

Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, албан тушаалаа урвуулан ашигласан гэх асуудалтай холбоотой сумдад 18, агентлагуудад 26, аймгийн Засаг даргын Тамгын газарт бичгээр 20, 7048-1111 тусгай дугаарын утсанд 33, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвд 7, төрийн албаны салбар зөвлөлд 1, нийт 33 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс албан тушаалаас чөлөөлсөн 6, сахилгын шийтгэл ногдуулсан 1, анхааруулах болон сануулах арга хэмжээ авсан 5, өргөдөлд нэр дурдагдсан албан тушаалтан, холбогдох эрх бүхий албан тушаалтнаас тайлбар мэдээлэл авч иргэнд хариу хүргүүлсэн 12, холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх тухай хариу өгсөн 18, тайлбар мэдээлэл хүргүүлсэн 29, хугацаандаа судлагдаж байгаа 6 байна.

Эмч эмнэлгийн ажилчидтай холбоотой 26 гомдол ирснийг аймгийн Эрүүл мэндийн газарт шилжүүлэн шийдвэрлэлээ. Улсын хэмжээгээр эрт илрүүлгийн үзлэг оношилгоо хийгдэж байгаатай холбогдуулан ачаалал нэмэгдэх, дурангийн үзлэг оношилгоо дараалал ихтэй байх, иргэд мэдээлэл хангалтгүйгээс үйлчилгээг авахдаа хүндрэлтэй байх зэрэг нь эмч эмнэлгийн ажилтнуудын талаар болон эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааны талаар гомдол, мэдээлэл ирүүлэх нөхцөл болж байна.

Канад улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд “Төрийн албан хаагчийн шударга, зарчимч байдал ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага” сэдэвт сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч 25 агентлаг, 15 байгууллагын удирдлагууд, Есөнбулаг сумын сургууль цэцэрлэгийн эрхлэгч, нийт 48 байгууллагын 189 албан хаагч хамрагдаж, төрийн албаны шинэтгэл, цаашдын чиг хандлагын талаар чадавхижлаа.

Нийт өргөдөл, гомдлын 6,6% буюу 166 нь ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн өргөдөл бүртгэгдсэнээс сумдын Засаг даргын Тамгын газарт 101, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудад 48, аймгийн Засаг даргын Тамгын газарт 17 өргөдөл ирсэн байна. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт эрүүл мэндийн шалтгаанаар 6, өөр ажилд шилжин ажиллахаар 5, суралцахаар 1, хувийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн 5 өргөдөл ирж, шийдвэрлэгдсэн байна.

Хандив тусламж дэмжлэг хүссэн өргөдөл 68 буюу нийт өргөдөл гомдлын 2,8%-ийг эзэлж байна. Сумдын Засаг даргын Тамгын газарт 30, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагт 10, аймгийн Засаг даргын Тамгын газарт 28

хүсэлт ирүүлснээс аймгийн Засаг даргын Тамгын газарт эмчилгээний мөнгөн тусламж хүссэн 2 иргэнд нийт 5,0 сая төгрөг, сургалтын төлбөрийн дэмжлэг 1 иргэнд 1,0 сая төгрөг, олон улсын уралдаанд оролцоход замын зардалд зориулан 1 иргэнд 2,0 сая төгрөгийн мөнгөн тусламжийг аймгийн Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэж, 1 иргэнд ажлаас чөлөөлөгдсөний 6 сарын цалинтай тэнцэх тэтгэмж олгон, 2 хүсэлтийг Онцгой байдлын газар болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт шилжүүллээ. 18 хүсэлтэд “Төрийн хэмнэлтийн тухай хууль” хэрэгжсэнтэй холбогдуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжгүй тухай мэдэгдэж, өргөдөл гаргагч өөрийн хүсэлтээр 2 өргөдлийг буцааж, 1 хүсэлт хяналтын хугацаандаа судлагдаж байна.

Хүнсний аюулгүй байдал, ил задгай худалдаалж буй бүтээгдэхүүний талаар ирүүлсэн иргэдийн хүсэлтийн дагуу цагаан идээний захыг нүүлгэн шилжүүлж, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газартай хамтран ил задгай мах худалдаалж буй иргэдэд шаардлага хүргүүлэн ажиллалаа. Хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийн тодорхойлолт гаргуулах 96, барилга барих зөвшөөрөл, барилгын чанар, аюулгүй байдал зам засвар, дүгнэлт гаргуулах 82 өргөдөл ирсэнээс шийдвэрлэх боломжтой 18-г нь газар дээр нь шийдвэрлэн бусад хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж албан бичгээр өгсөн.

Хот тохижилт, цэвэр бохир ус хангамж, халаалт дулаан, цахилгаантай холбоотой асуудлаар ирсэн 168 өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагуудад шилжүүлэн хугацаанд нь шийдвэрлүүллээ.

Бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ авах 49 хүсэлтийн шаардлага хангасан 30 бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгож, 8 газарт хугацаатай үүрэг даалгавар өгсөн байна.

3 иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хүнсний бүтээгдэхүүний Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лабораторит 11 сорьц 31 үзүүлэлтээр нян, хорио цээрийн шинжилгээ хийснээс хүнсний бүтээгдэхүүний 3 сорьц 3 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй тул сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 253 дугаар тушаалын дагуу 36000 төгрөгийн нэхэмжлэхийг холбогдох байцаагчид шинжилгээний хариутай хавсарган хүргэсэн байна.

2 иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Мэргэжлийн хяналтын газраас төлөвлөгөөт бус шалгалт үүсгэн, 2 ажилтны илүү цагийн цалин хөлс олгоогүй 1 байгууллагад 1.4 сая төгрөгийн илүү цагийн цалин хөлс нөхөн олгуулахаар улсын байцаагчийн акт үйлдэж, 1 төлөвлөгөөт бус шалгалтын ажил дуусаагүй үргэлжилж байна. Геологи уул уурхай, байгаль орчны чиглэээр иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 08/30 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж 2 иргэнд улсын байцаагчийн хамтарсан 18 заалттай 4 албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 5 иргэнд 780.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж 100% барагдууллаа.

Гэр бүл хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 47 дуудлага мэдээлэл, 1 гомдол ирснийг хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл сэтгэл санааны хүчирхийлэл 11, үл хайхрах хүчирхийлэл 13, бие махбодийн хүчирхийлэл 11, зөвлөгөө мэдээлэл хүссэн 2 байна. 27 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлдлийг үзүүлж, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 9 асуудлыг

сумдын “Хамтарсан баг”-т шилжүүлэн арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгөн, хяналт тавин ажиллаж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар улирал бүрийн нэгдсэн дүнг аймгийн албан ёсны сайт, Үйлчилгээний нэгдсэн төвийн самбарт байршуулж, иргэдээс санал хүсэлт ихээр ирж байгаа асуудлын талаар орон нутгийн “Алтай” телевиз болон аймгийн Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудсаар аймгийн удирдлагууд болон холбогдох албан тушаалтнуудад мэдээ мэдээлэл, тодруулгыг цаг тухай бүрт нь өгөн ажиллаж байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Говь-Алтай аймгийн Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс
ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга
/2022 оны 3-р улирлын байдлаар, өссөн дүнгээр/

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудлын нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь				
		Нийт өргөдлөөс:		тоо	эзлэх хувь	
1	Говь-Алтай аймаг	1	Хүсэлт	1995	90.15%	
		2	Гомдол	477	15.09%	
		3	Санал	58	2.62%	
		Өргөдөл гомдлын агуулга				
		1	Ажилд орохыг хүссэн	540	21.4%	
		2	Худалдан авалтын e-barimt олголттой холбоотой асуудлаар	298	11.0%	
		3	Хот тохижилт, амьдрах орчинтой холбоотой асуудлаар	105	4.8%	
		5	Ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн	166	7.8%	
		19	Төрийн байгууллагын үйлчилгээний чанар стандартын талаар	52	4.4%	
		6	Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахыг хүссэн	96	4.1%	
		8	Барилга орон сууцанд улсын комисс томилуулах, дүгнэлт гаргуулах тухай	82	3.6%	
		15	Төрийн албан хаагчийн ур чадвар, ёс зүйтэй холбоотой асуудлаар	88	3.7%	
		12	Төсөл хөтөлбөр, малжуулах төсөлд хамрагдах тухай	62	2.9%	
		4	Хандив, тусламж, дэмжлэг хүссэн	68	2.8%	
		11	Гэр бүл, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар	47	2.3%	
		7	Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ авах тухай	49	2.1%	
25	Алдарт эхийн одон авахыг хүссэн	29	2.1%			

18	Ковид-19, малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдалд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай	98	1.9%
13	Байгаль орчны талаар	56	1.7%
9	Цахилгаан, дулаан, цэвэр бохир, ус хангамж	42	1.5%
20	Хууль, журам зөрчсөн үйлдлийн тухай	35	1.3%
22	Худалдаа үйлчилгээний чанар, барааны үнийн өсөлттэй холбоотой	18	1.3%
10	Хяналт шалгалт хийлгүүлэх тухай	25	1.2%
24	Газрын маргаантай асуудлаар	19	1.0%
14	Хүнсний аюулгүй байдал, ил задгай худалдаалж бүтээгдэхүүний талаар	18	0.5%
17	Гэр олгохыг хүссэн	11	0.5%
23	Цэргийн дүйцүүлэх албанд орохыг хүссэн	2	0.2%
21	ЗД-ын бодлого үйл ажиллагаатай холбоотой	2	0.1%
16	Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахыг хүссэн	11	0.1%
26	Бусад асуудлаар	477	11.8%
	Дүн	2530	